

ОХУ: САНХҮҮГИЙН ХЯМРАЛААС ГАРЧ БУЙ БАЙДАЛ, ТӨЛӨВ

*Х.Мандухай**

Дэлхий дахиныг нөмөрсөн санхүүгийн хямралыг хохирол багатайхан шиг тойрон гарах боломжтой байгаа орнуудын тоонд манай хойд их хөрш ОХУ зүй ёсоор орж байна. ОХУ-ын төр засгийн энэ үеийн бодлого, үйл ажиллагаа нь чухамдаа банкуудыг дэмжихэд бус үйлдвэрлэгчдийг дэмжихэд чиглэж байгаагаараа онцлогтой байна. Оросын засгийн газар дэлхийн санхүүгийн хямралаас сэргийлэх зорилгоор юуны түрүүн үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, тухайлан томоохон экспортлогчиддоо илүү анхаарал тавьж халамж үзүүлэх тухай тодорхой шийдвэрийг эхлээд гаргасан. Энэ нь зохих үр дүнгээ өгч эхлэж байна. Энэ оны эхний 4 сард тус улсын эдийн засаг 9,8 хувиар буурч байв. Тэрчлэн хоёрдугаар улиралд ч эдийн засаг нь хумигдсан үзүүлэлтээ хадгалж байлаа. Тухайлвал, зургадугаар сарын байдлаар Оросын ДНБ өнгөрсөн мөн үеийнхээс 10.5 хувиар буурч гарсан. Харин энэ оны 8-р сарын сүүлийн байдлаар эдийн засаг нь 1.1 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна. Тийнхүү эдийн засгийн өсөлт буурч байснаа өсөх болсон нь ОХУ валютын үлэмж нөөц хуримтлуулж чадсанаар хямралыг ажралгүй даван туулах нэг чухал боломж бий болжээ. Үсрэнгүй хөгжиж байгаа том гүрэн ОХУ-ын хувьд нефтийн үнийн бууралт эдийн засагт нь том цохилт болсон хэдий ч байгалийн их баялгийн экспортоос бий болгосон эрсдлийн сангийн ачаар хямралыг хохирол багатай даван туулах бас нэг боломж бүрдэж байгаа аж. Өнөөдөр Оросын алт, валютын нөөц 450 триллион ам.доллараас давах болж, дэлхийн хэмжээнд гуравдугаарт орох боллоо.

Чухамхүү энэ их нөөц нь л Орос дахь Санхүүгийн хямралыг нимгэлэх, эдийн засгийн өсөлтийг хангах гол хүчин зүйл болж буй юм. Энэ тухай ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин 2009 оны 8-р сард Тувад хүрэлцэн ирэх үеэрээ мэдэгдлээ. Түүнчлэн ОХУ-ын тухайд 2010 онд макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч, ДНБ болон үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл өсөх магадлалтай байгааг тэрээр бас онцлон тэмдэглэлээ. Өнөөдөр Орос гүрний санхүү эдийн засагт үлэмж нөлөөтэй үндэсний тэрбумтан бизнесменүүдийн үйл ажиллагаа эрс сэргэж, хоорондын өрсөлдөөн идэвхжиж байна. Тухайлбал, Оросын хамгийн том алтны компани болох “Польюс Гоулд”-ын захирал Михаил Прохоров 14 тэрбумын хөрөнгөөрөө Олег Дерипаскаг ардаа орхин гарч ирлээ. Тэрбээр “Улс орноо дэлхийн эдийн засагт өрсөлдөхүйц болгохын тулд дэвшилтэт эдийн засаг бидэнд хэрэгтэй байна” хэмээн тунхаглаад “Газрын тос, байгалийн хий, алт, зэс, никель

* Х.Мандухай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

зэрэг байгалийн асар их баялгаа ухан гаргаж борлуулж байх биш, харин орчин үеийн тэргүүний технологи ашиглан баялгаа дотооддоо боловсруулвал илүү ашиг олно” гэж үзжээ. Тийнхүү Оросын томоохон бизнесменүүд өөрсдийн компаниудаа дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын энэ үед тэд зөвхөн өөрсдийн ашиг сонирхлыг бодох, үндсэрхэн явцуурах үзэл хандлага ямар ч тус нэмэр болохгүйг онцлон тэмдэглэж байна. Дээр дурдсан ахиц дэвшил гарч буй авч, манай хойд хөрш, эрчим хүчний товааруудын дэлхийн хамгийн том нийлүүлэгчдийн нэг Орос улсын эдийн засаг сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд байгаагүй хамгийн доод түвшиндээ байгааг Ерөнхийлөгч Д.Медведев мэдэгдсэн. Хямралын таагүй уур амьсгал нөмрөхөөс өмнө тус улсын эдийн засаг хэдэн жил дараалан 7-8 хувиар өсч байсан сайхан цаг ард хоцорчээ. Мэдээж одоо их Орос хямралаас гарахын тулд дэлхий нийтийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дэмжиж байгаа. Сүүлийн үед дэлхийн зах зээлд товааруудын ханш өсөж байгаа нь ОХУ-ын гадаад худалдааны орлого өсөхөд нөлөөлж буй аж. Түүнчлэн Орос гадаад худалдаа хийдэг орнууддаа валютынхаа нөөцийн тодорхой хэсгийг рублиэр байршуулахыг санал болгож буй нь дотоод эдийн засагаа ханшийн эрсдлээс хамгаалах зорилготой юм. Гэхдээ тус улсын Сангийн сайд А.Кудрин хямралын эсрэг либералчилсан бодлого явуулбал Хятадын юанийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө их болно гэж мэдэгдсэн. Харин судлаачдын үзэж байгаагаар Хятадын экспортын болон төлбөрийн баланс сайн гарч, долларын нөөцөөр дэлхийд тэргүүлж эхэлвэл юанийн ханш чангарах төлөвтэй байгаа юм. ОХУ үндсэндээ 2000 оноос хойш нефтийн маш их хэмжээний орлоготой байсан боловч энэ нөөц мөнгө нь 2010 онд бараг дуусах байдалтай болж байна. Маш их хэмжээний мөнгө гадагшаа гарсан байна. Оросын компаниуд хөрөнгө оруулалт хийх бололцоо нь ихээхэн багассан. Ийм учраас Монголд үзүүлэх нөлөөлөл нь гэвэл манай улстай хамтран хэрэгжүүлэх гэж байсан олон төслийн боломж хумигдсан. Санхүүжилтийн боломж нь багассан байгаа. Төслүүдийн хувьд тодорхойгүй гэж хэлж болно. Энэ тодорхойгүй байдал манайд эргээд сөрөг нөлөө үзүүлж байгаа. Үүний хамт хойд их хөршид санхүү эдийн засгийн хямралаас гарч буй байдал төлөв, тэнд баримталж буй гол бодлогын стратеги чиг шугам нь бидний судалж мэдүүштэй, санаа авууштай чухал чиглэл мөн. Нөгөөтэйгүүр ОХУ хямралаас гарах боломж, нөхцөл байдлаа нээж, ил тод болгохын тулд Ази дахь хөрш орнууд, ялангуяа хятад, японтой тогтоосон харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг хүсэж байна. Үүндээ урьд тогтоосон харилцааны суурь дэвсгэр дээр суурилуулан эдийн засаг, худалдаагаа өргөтгөн, өөртөө ашигтай хэлбэр, арга замыг сонгохыг хичээж байгаа.

Орос-Хятад: Зөвлөлт Холбоот Улсын задралаас хойш ОХУ өөрийн шинэ байр суурь, үүрэг ролио хайж чиг хандлагаа эрэлхийлж байна. Геополитик талаас болж өгвөл олон, болохгүй бол ямар ч байсан ганц туйлт биш дэлхий ертөнцийг ОХУ улс төр, эдийн засгийн шинэтгэлийн хэрэгсэл болгон интеграцийг чухалчлан ойлгож байна. Энэ үүднээс ч тэд ЗХА-д хандаж байна. “ЗХА-д аюулгүй байдлыг хангах тогтолцооноос эдийн засгийн хамтын ажиллагаанд тулгуурласан” системд шилжих нь зүйтэй гэж ОХУ үздэг болж байна. /Anna V.Shkurapat, 2002/

Стратегийн хэд хэдэн хамтын сонирхолд тулгуурласан ОХУ, БНХАУ-ын харилцаа нь ойрын жилүүдэд улам ойртож байна. “Олон туйлт дэлхий”-г дэмжих, аль нэгэн гүрэн дангаараа ноёрхох аливаа байдлаас сэрэмжлэхээ хоёр улс илэрхийлж байгаа. Гэхдээ Орос-Хятадын түншлэл нь Америкийн эсрэг эвсэл гэдгээс их хол бөгөөд Барууны улсууд, АНУ зэрэг бусадтай хамтын ажиллагаа өргөжүүлэх бодлогод захирагдаж байгаа гэж зарим судлаачид үзэж байна. /Aleksander Lukin, 2001/

Гадаад худалдааны хувьд жилийн өсөлт бараг 20% болж 20 млрд.ам.долларт хүрсэн хэдий ч Хятад-АНУ-ын 350 гаруй млрд.ам.долларын худалдаатай харьцуулбал Орос, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа маш бага байгаа юм. Хятад зүүн-хойд бүсээ эрчимтэй хөгжүүлэхийн тулд Оросын Алс Дорнодод хөрөнгө оруулалт хийх, хамтын ажиллагааны төслүүд хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа юм. Хятадууд Алс Дорнодод бөөнөөр суурьшиж байгаа нь Оросын хувьд “толгойн өвчин” болоод байгаа бөгөөд энэ асуудлаас үүдэн Оросын зарим судлаачид бүс нутгийн болон хил хавийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудалд эргэлзэж байгаа юм.

Орос-Япон: ЗХА-ийн хамтын ажиллагааны асуудлыг Япон 1960-аад оны үед анх санаачилсан бөгөөд хоёр улсын харилцааг хэвийн болгох 1973 оны Хэлэлцээр бүтэлгүйтсэнээс болоод Зүүн Өмнөд Ази руу анхаарлаа хандуулсан гэдэг. 1980-аад оны төгсгөлд асуудлыг дахин сөхөж эхэлсэн билээ. Япон далайн эрэг хавийн “Мартагдсан бүс” нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар эл нутгаа хөгжүүлэх чиглэл Япон баримталж эхэлсэн юм. Японы уламжлал, соёлын эх ЗХА-аас гаралтай гэж Япончууд үздэг. /Gilbert Rozman, 1999/

Түүхэн үүднээс авч үзвэл, Оросын Алс Дорнодын түүхий эдийг ашиглах “цонхтой” болох нь Японы хувьд стратегийн бодлого байсан юм. Энэ утгаараа, Оростой, түүний эл бүстэй холбоотой удаан хугацааны эдийн засгийн харилцаа хөгжүүлэх нь Японы сонирхол юм. 1990-ээд оноос хоёр улсын харилцаа нилээд прагматик шинжтэй болж эхэлсэн. Эл бүс нутагт байгалийн хий, нефть зэрэг түүхий эдийг ашиглах сонирхолтой байгаагаа Япон тод илэрхийлсэн юм. Жишээ нь 5 млрд.ам.долларын өртөг бүхий 4000 км урт хоолой Сибирээс Находка хүртэл татах төслийг Япон санал болгосон юм. Нефтийн

хэрэгцээнийхээ 80%-ийг Ойрхи Дорнодоос татдаг Япон шинэ эх үүсвэр хайж байгаа бөгөөд эл утгаараа Орос, Алс Дорнод стратегийн хувьд ач холбогдолтой юм.

Хэдийгээр эдийн засгийн хамтын ажиллагааны асар их бололцоо байгаа ч эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа удаан байна гэж шинжээчид үзэж байгаа юм. Үүний учир шалтгаан нь дэлхийн хоёрдугаар дайн болон “Хүйтэн дайн”-аас үүдэлтэй юм. “Хойд нутгийн асуудал” гэгчийг Япончууд олон жил хөндөж байгаа ч шийдэл нь харагдахгүй л байна. Японы хувьд “Хойд нутаг” гэдэг нь эдийн засгийн гэхээсээ илүү улс төрийн утга учиртай зүйл юм. Японтой харилцаж ирсэн, эдүгээ харилцаж байгаагаа хямралаас гарах чухал гарц гэж үзэх боллоо.

Ашигласан материал:

1. <http://www.mid.ru/ns-dipecon.nsf/>
2. <http://kremlin.ru/>
3. <http://russian.people.com.cn/>
4. Өдрийн сонин 2008.12.09
5. Зууны мэдээ 2009.08.11
6. Anna V.Shkuropat “New Dynamics in Northeast Asia: The Russia factor”, CNAPS. Working paper July 2002
7. Александр Лукин Орос-Хятадын харилцаа CNAPS. Working paper May 2001
8. Gilbert Rozman “ Backdoor Japan...” Journal of Japanese Studies №25 1999